



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар \_\_\_\_\_

Сүхбаатар сум

Г Сүхбаатар сумын Иргэдийн төлөөлөгчдийн Г  
хурлын Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт  
шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 12 дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Сүхбаатар сум дахь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Ахлах дотоод аудитор Т.Мөнхзул, Дотоод аудитор Г.Дорждэрэм нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөс ажлын 25 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх)-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Сүхбаатар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь улсын бүртгэлийн 373716 дугаар регистртэй, 1370001146 дугаарт бүртгэлтэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131454001, нэмэлт санхүүжилтийн 100131454401 дугаар данстай.

Санхүү, татварын баримтад 1-р гарын үсгийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Гантулга, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Ууганбаяр нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайланг гаргаж ирсэн байна.

1.5 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 41 дүгээр хуралдаанаар сумын ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог баталсан. Үүнд улс төрийн албан тушаалтан 1, төрийн захиргааны албан хаагч 2, төрийн үйлчилгээний албан хаагч 1, нийт 4 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна

1.6 Сумын ИТХ нь 28 төлөөлөгчтэй, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах

чиг үүрэг бүхий Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо, Төсөв санхүү хөрөнгө оруулалт эдийн засгийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, Өргөдөл гомдол хууль хяналтын бодлогын хороо зэрэг хурлын хороо байгуулан ажиллуулж, хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

1.7 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 3 удаа, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл 6 удаа, багийн иргэдийн Нийтийн Хурал тус бүр 1 удаа хуралдуулсан. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс голлон анхаарч ажилласан байна.

1.8 2024 оны 3 дугаар улирлын байдлаар ИТХ нь 3 удаа хуралдаж газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөө батлах тухай-1, Эд хөрөнгө акталж, данснаас хасах тухай 1, Цалин хөлсний жишиг тогтоох тухай 1, Сонгуулийн хэсэг байгуулах тухай 1, Сонгуулийн хэсэг шинэчлэн байгуулах тухай 1, Сонгуулийн сурталчилгааны самбарын байршил тогтоох тухай 1, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрог байгуулж, мандатын тоо, хэсгийн төв, дугаар, нутаг дэвсгэрийн тогтоох тухай 1, Журам батлах тухай 1, Ухуулах хуудас, зурагт самбарыг байршуулах байршил тогтоох тухай 1 нийт 9 асуудлыг шийдвэрлэж ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан байна.

Үүнд:

№	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдсан огноо	хурлаар		Ирц /Хувь/
		Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэлт (тогтоолын дугаар)	
1	2024.01.30.	Түлээний модны хуваарь батлах тухай	126	85.7%
2		Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний биелэлт, 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай	127	
4		Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөлд зээл олгох тухай салбар чиглэл батлах тухай	128	
5		Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай	129	
6		Мал амьтны шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө батлах	130	
7		Малын тоо толгойн албан татварт өөрчлөлт оруулах тухай	131	
8		Бодлогын хороодын төлөвлөгөө батлах тухай	132	
9		Журам батлах тухай	133	
10		Сонгуулийн хэсэг байгуулах тухай	134	
1		2024.04.09	МУИХ-ын сонгуулийн зурагт самбарыг байршуулах байршил тогтоох тухай	
2	Сумын ИТХ-ын сонгуулийн Төлөөлөгчдийн мандатын тоо батлах тухай		136	
3	Сэлэнгэ аймгийн Прокурорын тогтоолын тухай		Тогтоол гараагүй	

4		Сүхбаатар суманд газар эзэмших ашиглах гэрээ дүгнэх ажлын хэрэгжилтийн талаар	137	
5		2024 оны Улс, аймаг, сумын төсөв ОНХС-аар хийгдэх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил арга хэмжээний явцын талаар	Тогтоол гараагүй	
6		2023 онд унасан мод бэлтгэлийн ажлын талаар	Тогтоол гараагүй	
7		Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн захирамжийн талаар	Тогтоол гараагүй	
8		Халаалтын төвийн тухай	138	
1	2024.05.20	Сумын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	139	61,9%
2		Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	140	
3		Хөрөнгө актлах тухай	141	
4		Өмч ашиглуулах тухай	142	
5		Хүлэмж, парк, усалгааны тоног төхөөрөмж		
6		Хогны автомашин ашиглуулах Шахмал түлшний цехийн тоног төхөөрөмж	143	
7		Сонгуулийн хэсэг байгуулах тухай	144	
8		Ээлжийн амралт олгох тухай		

### Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

#### 2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувь, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 95.0 хувь, сумын ИТХ-ын даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт эхний 3 дугаар улирлын байдлаар 70 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.1.2 ИТХ-ын нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажсан захиргааны байгууллагын захиргааны актад утга, агуулгын алдаагүй бодит нөхцөл байдлыг тогтоосон, эрх зүйн үндэслэл хэсэгт нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актын зүйл заалтыг ашиглахгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.1.3 Сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

#### 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

## 2.2.1 Батлагдсан төсөв:

Сумын ИТХ-ын төсөв нь үйл ажиллагааны болон ажлын албаны төсвөөс бүрддэг бөгөөд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 609,973.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж 308,810.0 төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 51% хувь байна.

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>609,973.90</b>	<b>308,810.04</b>	<b>301,163.87</b>	<b>51%</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>609,973.90</b>	<b>308,810.04</b>	<b>301,163.87</b>	<b>51%</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>538,391.90</b>	<b>285,228.04</b>	<b>253,163.87</b>	<b>53%</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>221,704.20</b>	<b>145,186.55</b>	<b>76,517.65</b>	<b>65%</b>
210101	Үндсэн цалин	88,402.50	77846.99	10,555.51	88%
210102	Нэмэгдэл	76,612.50	49,352.48	27,260.02	64%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,780.00	2,610.00	1,170.00	69%
210104	Урамшуулал	52,909.20	15,377.08	37,532.12	29%
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,713.10</b>	<b>17,851.39</b>	<b>9,861.72</b>	<b>64%</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,844.90	12,331.97	6,512.93	65%
210202	Тэтгэмжийн даатгал	2,217.10	1,418.70	798.40	64%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,108.50	709.25	399.26	64%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,108.50	663.87	444.63	60%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,434.10	2,727.60	1,706.50	62%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,878.80</b>	<b>8,880.40</b>	<b>6,998.40</b>	<b>56%</b>
210401	Бичиг хэрэг	4,100.00	1241.8	2,858.20	30%
210402	Тээвэр, шатахуун	10,000.00	6670	3,330.00	67%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	910	584.10	325.90	64%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	868.80	384.50	484.30	44%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,731.20</b>	<b>11,720.00</b>	<b>11.20</b>	<b>100%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,731.20	1720	11.20	99%
210604	Урсгал засвар	10,000.00	10,000.00	0.00	100%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,112.00</b>	<b>3222.6</b>	<b>1,889.40</b>	<b>63%</b>
210702	Дотоод албан томилолт	5,112.00	3222.6	1,889.40	63%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,850.60</b>	<b>2,722.00</b>	<b>29,128.60</b>	<b>9%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,450.00	2,700.00	28,750.00	9%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	184.7	0	184.70	0%
210806	Даатгалын үйлчилгээ	122.4	0	122.40	0%

	Тээврийн хэрэгслийн татвар	52.5	0	52.50	0%
	Тээврийн хэрэгслийн оношилгоо	41	22	19.00	54%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>224,402.00</b>	<b>95,645.10</b>	<b>128,756.90</b>	<b>43%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	216,902.00	95645.1	121,256.90	44%
210902	Хичээл үйлдвэрийн дадлага	7,500.00	0	7,500.00	0%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,582.00</b>	<b>9,582.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,582.00</b>	<b>9,582.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,582.00	9582	0.00	100%
<b>81505</b>	<b>ИТХ-д суудалтай намуудад олгох</b>	<b>62,000.00</b>	<b>14,000.00</b>	<b>48,000.00</b>	<b>23%</b>
213101	ЗГ-н дотоод шилжүүлэг	62,000.00	14,000.00	48,000.00	23%
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>609,973.90</b>	<b>308,810.04</b>	<b>301,163.87</b>	<b>51%</b>
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>609,973.90</b>	<b>308,810.04</b>	<b>301,163.87</b>	<b>51%</b>
1320001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	609,973.90	308,810.04	301,163.87	51%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	78,869.20	-78,869.20	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>100</b>
620001	Удирдах ажилтан	2	2	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2	-	100
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>100</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	2	2	-	100
650001	Төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮ)	1	1	-	100
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	-	100

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 308,810.0 мянган төгрөг буюу 51.0 хувьтай байгаа нь Орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 301,163.9 мянган төгрөгөөр дутуу байгаатай холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 76,517.7 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 9,861.7 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 6,998.4 мянган төгрөгөөр, тавилга эд хогшлын зардлыг 11.2 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,889.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 29,128.6 мянган төгрөгөөр, ИТХ-д суудалтай намуудад олгох зардлыг 48,000.0 мянган төгрөгөөр зарцуулаагүйтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна. Учир нь бараа үйлчилгээний зардлыг хэт

өндрөөр, Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох тухай хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байхад аймгийн ИТХ-д суудалтай намуудад 62,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор тус тус төлөвлөсөн нь тодорхой харагдаж байна.

### 2.3. Санхүүгийн үйл ажиллагааны явц, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт

**Үндсэн хөрөнгө:** ИТХ нь 2024 оны эхэнд 36,717.2 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр, 1,630.0 мянган төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авсан байна. 42,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Camery маркийн автомашин Засаг даргын тамгын газраас шилжүүлэн нийт 80,347.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бараа материал:** 2024 оны эхэнд 1,061.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас төсвийн хөрөнгөөр 16,155.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 9,835.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж 7,381.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### Өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хөдлөлийн утга	Орлого зарлагын гүйлгээний утга	Өмч хөрөнгө:	
			Үндсэн хөрөнгө	Бараа материал
1	Оны эхний үлдэгдэл		36,717.2	1,061.3
2	Төсвийн эх үүсвэрээр	худалдан авсан	1,630.0	16,155.3
3	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	шилжүүлэн авсан	-	-
4	Бусад /дахин үнэлсэн/	шилжүүлэн авсан	-	-
5	Бусад	Хандив	42,000.0	-
6	Орлогын дүн		80,347.2	17,216.6
7	Үйл ажиллагаанд зарцуулсан	анхан шатны баримт	-	9,835.5
8	Элэгдэл	шилжүүлсэн	19,834.9	-
9	Акталж данснаас хассан	тушаалаар	-	-
10	Зарлагын гүйлгээний дүн		19,834.9	9,835.5
11	Оны эцсийн үлдэгдэл		60,512.4	7,381.1

Бараа материалын орлого болон зарлагыг тухай бүр хүлээн зөвшөөрч, тайлан бүртгэлд тусгаагүй улирлаар бөөн дүнгээр бүртгэсэн байсныг хяналт шалгалтын явцад залруулсан.

## 2.4 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024 оны 3 дугаар улирлын байдлаар сумын ИТХ-ын ажлын албаны цалинг ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны 01 дугаарын сарын 24-ны өдрийн Б/01, Б/02 дугаар тушаалаар, 2024 оны 04 сарын 01-ны өдрийн Б/05, Б/13 дугаар тушаалаар тус тус удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл хийсэн дүн шинжилгээ хийлээ: сумын ИТХ нь 4, багийн иргэдийн нийтийн хурал 8, нийт 12 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж цалин хөлс, нэмэгдэлд, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 27,713.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 17,851.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад: Сумын ИТХ-ын бүтэц орон тоо баталсан тушаалд Төрийн үйлчилгээний туслах /нярав-жолооч/ гэсэн албан тушаалын ажил үүргийг үндсэн ажилтнаар баталсан боловч, цалин шинэчлэн тогтоох тушаалд гэрээт ажилтнаар баталж тус ангиллын цалингийн сүлжээгээр цалинжуулж олгосон байна.

## 2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт байхгүй байна. Үүнд:

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл,	Төрөл (бараа, ажил, үйлчилгээ)	Төсөвт өртөг (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга	Тайлбар, тодруулга
Бичиг хэрэг	Бараа	4,100.0	ШГБ	ТБОНӨХБАҮХАТ хуулийн босго онооноос доогуур
Тээвэр шатахуун	Бараа	10,000.0	ШГБ	
Багаж, техник, хэрэгсэл	Бараа	1,731.2	ШГБ	
Шуудан холбооны зардал	Үйлчилгээ	910.0	ШГБ	
Баг үнэтэй түргэн элэгдэх	Бараа	868.8	ШГБ	
Бараа үйлчилгээний бусад зардал	Үйлчилгээ	136,902.0	ШГБ	
Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	Үйлчилгээ	7,500.0	ШГБ	
Нийт		162,012.0		

Сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах 12,797.3 мянган төгрөгийн 3 гэрээг иргэн, хуулийн этгээдтэй хийж ажил гүйлгээг

гүйцэтгэсэн ч төлбөр тооцооны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, гэрээний хэрэгжилтийн үр дүнг тооцоогүй байна.

## 2.7 Өмнөх шалгалтын талаар

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн шийдвэрлэлт	2023 он				
	Үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь
Төлбөрийн акт	1	640.00	1	190.00	42.2
Албан шаардлага	1	5,670.00	1	5,670.00	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>6,310.00</b>	<b>2</b>	<b>5,860.00</b>	<b>71.1</b>

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023 онд, томилолтоор ажилласан албан хаагчдын хоолны мөнгийг давхардуулан олгосон 640.0 мянган төгрөгийн төлбөрийн актаас 190.0 мянган төгрөгийг барагдуулж 42.2 хувийн, ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааны үеийн хоолны зардлыг бодит ирцээр бус төлөөлөгчдийн тоогоор тооцож илүү зарцуулсан 5,670.0 төгрөгийн албан шаардлагын биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

### Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сүхбаатар сумын ИТХ-ын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлт, шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөөр хангалттай сайн, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон бол хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

### Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

**Илрүүлэлт 1.** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй шууд гэрээ байгуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж 2020-2024 оны тогтоол шийдвэр, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын тайлангийн эх бэлтгэх, хэвлүүлэхэд 20,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх "...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ..... холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 2.** Төрийн хэмнэлтийн тухай хууль болон худалдан авах ажиллагааны хуулийг баримтлаагүй шууд гэрээ байгуулж 2020-2024 онуудын тогтоол шийдвэр, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын дүрс бичлэг, контент хийхэд 22,500.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", ТБОНЭХБАУХАТ Хуулийн 31 дүгээр зүйлийн 31 .1 дэх "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөг үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:", 31.1.2. дэх "харьцуулалт;" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20 сая төгрөг, ажил -20 сая төгрөг" -тэй тус тус нийцэхгүй байна

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхгүй байх, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 3.** Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй арга хэмжээний хүрээнд 4,260.0 мянган төгрөгийн зардлын тайлан хангалтгүй, бичлэгийг баримтжуулахгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 1,800.0 мянган төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудсыг спидометрийн заалт, автомашины 100 км норм зэргийг дутуу бүртгэсэн зэрэг нийт 6,060.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ хийж бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 дах "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Төрийн хэмнэлтийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.-тай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Анхан шатны баримтын бүрдэл нь хууль, эрхийн актад нийцсэн, иж бүрэн, үнэн зөв байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 4.** Илтгэх индрийн ирээдүй ТББ-тай гэрээ байгуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод сургагч багш бэлтгэх 100 цагийн сургалтад 10 иргэнийг хамруулж 13,000.0 мянган төгрөгийг шилжүүлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 дах "Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5 дах "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7 дах "төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах"тай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 5.** Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж Сар шинийн баяраар 4 ажилтан албан хаагчид 800.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр "Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа", "Төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгаа"-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 6.** Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох тухай хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байхад аймгийн ИТХ-д суудалтай намуудад 14,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Улс төрийн намын хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх "Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид "нийт сонгогч" гэх/-ийн тоог ..... төрийн санхүүжилт олгоно"той тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Улс төрийн намын хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх "Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид "нийт сонгогч" гэх/-ийн тоог ..... төрийн санхүүжилт олгоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 7.** Сумын ИТХ-ын бүтэц орон тоо баталсан тушаалд Төрийн үйлчилгээний туслах /нярав-жолооч/ гэсэн албан тушаалын ажил үүргийг үндсэн ажилтнаар баталсан боловч, цалин шинэчлэн тогтоох тушаалд гэрээт ажилтнаар баталж тус ангиллын цалингийн сүлжээгээр цалинжуулж олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно", 57 дугаар зүйлийн 57.17 дах Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно. гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** ИТХ-ын бүтэц орон тоо баталсан тушаалын ангиллын цалингийн сүлжээгээр цалинжуулах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 8.** Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах захиргааны шийдвэр гаргахдаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь хэсэгт заасан бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг үндэслэсэн нь хууль тогтоомжоор эрх олгосон нарийвчлан зүйл заалтыг үндэслээгүй байгаа нь Захиргааны процессын хууль зүйн техникийн зөв ашиглаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь "Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой заана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой бичиж байх зөвлөмж хүргүүлэв.

**Илрүүлэлт 9.** Тугийн үнэ 140.0 мянган төгрөг, автомашины шалавчны үнэ 320.0 мянган төгрөг, суудлын бүрээсний үнэ 450.0 мянган төгрөг, автомашины тенийн үнэ 245.0 мянган төгрөг, гэрчилгээний дугаарын үнэ 77.2 мянган төгрөг, даатгалын төлбөр 81.7 мянган төгрөгийн нийт 1,313.9 мянган төгрөгийг бараа ажил үйлчилгээний бусад зардлаас, Төрийн захиргааны албан тушаалд 5 жил тасралтгүй ажилласан төрийн жинхэнэ албан хаагчид олгох мөнгөн урамшуулал 8,282.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас, нийт 9,595.9 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 210901-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг баримталж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

#### **Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

##### **4.1 Дүгнэлт:**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Сүхбаатар сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 оны 3 дугаар улирлын санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын ИТХ-ын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

##### **4.2 Шийдвэрлэлт:**

Сүхбаатар сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 106,598.3 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 800.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 96,202.4 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлэх, асаг даргын хөрөнгө зарцуулах захиргааны шийдвэр гаргахдаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь хэсэгт заасан бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг үндэслэсэн нь хууль тогтоомжоор эрх олгосон нарийвчлан зүйл заалтыг үндэслэлтэй тусгаж байх, урсгал зардлыг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх зэрэг 2 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

**Тав.Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:**


Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж 800.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг төсвийн дансанд төвлөрүүлэх, 96,202.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус сумын ИТХ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

**БИЧСЭН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД  
АУДИТОР  ДОРЖДЭРЭМ

**ТАНИЛЦСАН:**

СҮХБААТАР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧИЙН ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

Д.ГАНТУЛГА

Б.УУГАНБАЯР